



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан.



Өндөрхангай сумын төсөвт байгууллагууд цалин хөлс, нэмэгдлийг олгохдоо зарим хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байна.

Өндөрхангай сумын төсөвт байгууллагуудын 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн

2017 оны 9 дугаар сар

<u>Тайлан бэлтгэсэн:</u> Дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Батсуурь Аудитын менежер М.Бат-Амгалан Аудитор Т.Намжил С.Батсайхан 2017 оны 10 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317, 7045-3721, 70453799 дугаарын утсаар харилцана уу. Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум, 3 дугаар баг, Засаг даргын тамгын газрын байр	Агуулга Товчилсон үгийн тайлал Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Ерөнхий мэдээлэл Бүлэг 1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. 1.1. Батлагдсан төсвийн зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. 8-9 1.2. Цалин хөлс, нэмэгдлийг олгохдоо зарим хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байна. 9-10 1.3. Авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнасан байна 10-11 1.4. Төсөвт байгууллагууд бараа ажил үйлчилгээг хууль, тогтоомжийн дагуу бэлтгэн нийлүүлсэн байна. 11 Бүлэг 2. Бараа материал болон үндсэн хөрөнгийн ашиглалт хэвийн, хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналт сул байна 11 2.1. Бараа материалын зарцуулалтанд тавих хяналт сул байна. 2.2. Үндсэн хөрөнгийн ашиглалт хэвийн, хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналт сул байна. 11 Бүлэг 3. Эмийн эргэлтийн сангаас зориулалт бус зардал гаргасан байна. 11-12 3.1. Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулаагүй байна. 3.2. Эмийн эргэлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт хэвийн, зориулалт бус зардал гаргасан байна. 13 3.3. Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт хэвийн байна. 3.4. Эмийн эргэлтийн сангийн авлагыг данс бүртгэлд тусгасан байна. 13 Бүлэг 4. Шилэн дансы тухай хуулийн хэрэгжүүлэн ажиллаж байна. 13 4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэвийн байна. 14 4.2. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан байна. 14 Дүгнэлт 14 Зөвлөмж Холбогдох байгууллагын санал 14-15 Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар 15 16	
---	---	--

Товчилсон үгийн тайлал:

НА	- Нийцлийн аудит
ИТХ	- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	- Засаг даргын тамгын газар
ЭМТ	- Эрүүл мэндийн төв
ЭЭС	- Эмийн эргэлтийн сан
НББ	- Нягтлан бодох бүртгэл
ТБОНӨХБАҮХАТХ	- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХОАТ	- Хувь хүний орлогын албан татвар
ОНХС	- Орон нутгийн хөгжлийн сан
СХС	- Сум хөгжүүлэх сан
НД	- Нийгмийн даатгал

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Өндөрхангай сумын төсөвт байгууллагууд батлагдсан төсөв, хөрөнгө нөөцөө хууль тогтоомжийн хүрээнд зарцуулж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, үр нөлөөг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
- Үндсэн хөрөнгө, бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт байгаа эсэх
- Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
- Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

Аудитын хамрах хүрээ

Өндөрхангай сумын төсөвт байгууллагуудын 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа болон Эмийн эргэлтийн сан, Сум дундын ойн ангийн үйл ажиллагааг хамруулан хийж гүйцэтгэв.

Арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн бүртгэл, анхан шатны баримтыг тулган баталгаажуулах, бараа материал, үндсэн хөрөнгөд биет тооллого хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Энэхүү нийцлийн аудитыг явуулахад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын баталсан нийцлийн аудитын төлөвлөгөөг мөрдөж ажиллаа.

Нийцлийн аудитыг аудитор Т.Намжил, С.Батсайхан нар 2017 оны 9 дүгээр сарын сарын 04-нөөс 9 дүгээр сарын 15-ны хооронд ажлын 10 хоног хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Увс аймгийн Өндөрхангай сум нь 1922 онд байгуулагдсан. Цалуу, Батсайхан, Цагааннуур, Жаргалант, Цэцэрлэг гэсэн 5 багийн нийт 871 өрх, 3155 хүн амтай, 465.2 мянган га нутаг дэвсгэр, 144 мянган толгой малтай. Сумын хэмжээнд ИТХ, ЗДТГ, Ахлах сургууль, Сум дундын эмнэлэг, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Сум дундын ойн анги, Ханхөхийн нурууны УТХГНХЗ гэсэн төрийн байгууллага болон арилжааны ХААН банк, Төрийн банк, ШТС, холбооны салбар, худалдаа, үйлчилгээний чиглэлийн хувийн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

Нийцлийн аудитад хамрагдах 2015, 2016 онд сумын ИТХ-ын даргаар Л.Ичинхорлоо, М.Цэрэндорж, Засаг даргаар Ц.Сүхбаатар, Ц.Сундуй, ЗДТГ-ын даргаар Б.Гэрэлцэцэг, Ахлах сургуулийн захирлаар Ж.Пүрэвдорж, Я.Ганбаяр, Сум дундын эмнэлэгийн эрхлэгчээр Н.Чимэдцэрэн, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчээр Б.Цэндээжав, Соёлын төвийн эрхлэгчээр О.Уранчимэг, Сум дундын ойн ангийн даргаар Б.Батням, Санхүүгийн албаны даргаар Т.Цэрэнбат, төсөв, төрийн сангийн мэргэжилтнээр Д.Баянцэцэг, ИТХ, ЗДТГ, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Сум дундын ойн ангийн нягтлан бодогчоор Ж.Батпүрэв, Ахлах сургууль, Сум дундын эмнэлэг, Эмийн эргэлтийн сангийн нягтлан бодогчоор С.Сарангэрэл нар ажиллаж 1, 2 дугаар гарын үсэг зурж төсөв хөрөнгийг захиран зарцуулсан байна.

Эмийн эргэлтийн сангийн эрхлэгчээр Т.Оюунгэрэл ажиллаж, 1-р гарын үсгийг сумын Засаг дарга, 2-р гарын үсгийг Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч зурж захиран зарцуулсан байна.

Нийцлийн аудитын явцад төсвийн байгууллагууд болон Эмийн эргэлтийн сан, Сум дундын ойн ангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал хүсэлтийг хүлээн авахаар зарлал байрлуулж ажиллаа.

Бүлэг: 1

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

1.1 Батлагдсан төсвийн зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Өндөрхангай сумын төсөвт байгууллагуудын 2015, 2016 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

Д/Д	Байгууллагын нэр	2015 он			2016 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт
1	ЗДТГ	280.0	274.8	5.2	304.0	280.7	23.3
2	ИТХ	45.6	44.1	1.5	44.0	43.7	0.3
3	Сургууль	715.1	714.8	0.3	735.5	720.8	14.7
4	Цэцэрлэг	181.1	178.1	3.0	186.3	179.6	6.7
5	Соёл	63.9	63.2	0.7	57.4	55.3	2.1
6	Сум дундын эмнэлэг	404.6	397.5	7.1	406.9	405.8	1.1
7	Сум дундын ойн анги	42.3	42.3	0	36.1	35.6	0.5
Дүн		1732.6	1714.8	17.8	1770.2	1721.5	48.7

Эх сурвалж: Сумын ЗДТГ-ын Санхүүгийн албанаас мэдээллийг гаргуулж, тулган баталгаажуулсан

Засгийн газрын 2015 оны 147 дугаар “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу 2015 онд төсвийн хэмнэлтийн горимд шилжиж орон нутгийн захиргааны байгууллагуудын тэвчиж болох зардлын эрхийг нээгээгүйгээс санхүүжилт 17.8 сая төгрөгөөр танагдсан байна.

Сумын төсөвт байгууллагууд 2015 онд 17.8 сая, 2016 онд 48.7 сая төгрөгийн хэмнэлт гаргаж төвлөрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчиж ЗДТГ, Соёлын төвийн зарим ажилтнуудыг ажлаас халсныг шүүхийн шийдвэрээр ажилд нь эгүүлэн ороход ажиллаагүй хугацааны цалинг төсвөөс олгож үргүй зардал гаргасан байна. Үүнд:

- Соёлын төвийн эрхлэгчээр ажиллаж байсан Д.Долгорсүрэнг сумын Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 12-ны Б/15 дугаар захирамжаар халж, Шүүхийн 2015 оны 2 дугаар сарын 06-ны Б/02 дугаар захирамжаар эгүүлэн томилохдоо 33 өдрийн цалинд 985.9 мянган төгрөг, мөн сумын Засаг даргын 2015 оны 2 дугаар сарын 16-ны Б/04 дугаар захирамжаар халж, Шүүхийн 2015 оны 5 дугаар сарын 22-ны Б/17 дугаар захирамжаар эгүүлэн томилохдоо 54 өдрийн цалинд 1710.4 мянган төгрөгийг тус тус Шүүгчийн шийдвэрийн дагуу олгосон байна.

Харин ямар нэгэн шийдвэргүйгээр Д.Долгорсүрэнгийн хувийн өргөдлийн дагуу 2015 оны 5 сарын 1-нээс 5 сарын 25 хүртэлх хугацааны цалинд

530.4 мянган төгрөг олгосон байна. Засаг даргын тамгын газарт байгаль хамгаалагчаар ажиллаж байсан Х.Баттогтуурыг сумын ЗДТГ-ын даргын 2014 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар халж, 2015 оны 1 дүгээр сарын 08-ны А/01 дүгээр тушаалаар эгүүлэн томилохдоо Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалин 4981.7 мянган төгрөгийг төсвөөс олгожээ.

Уг асуудлаар гарсан Шүүхийн шийдвэрүүд нь тухайн ажилтныг ажилд эгүүлэн томилохоор гарсан байна. Энэ нь тухайн ажилтныг ажлаас чөлөөлсөн эрх бүхий албан тушаалтны шийдвэр нь эрх зүйн хувьд учир дутагдалтай байсныг харуулж байгаа бөгөөд төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахад хүргэсэн байна.

Цаашид шийдвэргүйгээр цалин, цалингийн нэмэгдлийг олгохгүй байхыг зөвлөж байна.

1.2 Цалин хөлс, нэмэгдлийг олгохдоо зарим хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3.-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасны дагуу сумын төсөвт байгууллагууд батлагдсан орон тоондоо багтаан ажиллажээ. Төсөвт байгууллагууд оны эхэнд албан тушаал, ажилтнуудын ажилласан жил, цалингийн сүлжээ, шатлал, үндсэн цалин, нэмэгдлийн хувь хэмжээг тогтоож баталсан тушаал шийдвэр гаргасан байна.

Төсөвт байгууллагуудын бүтэц, орон тоог хүснэгтээр харуулав.Үүнд:

Байгууллагын нэр	2015 он			2016 он		
	Батлагдсан	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт	Батлагдсан	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт
ИТХурал	7	7	-	7	7	-
ЗДТГазар	29	28	1	29	28	1
СДЭмнэлэг	33	33	-	33	30	3
Ахлах сургууль	71	71	-	61	61	-
Хүүхдийн Цэцэрлэг	15	15	-	13	13	-
Соёлын төв	9	9	-	5	5	-
Сум дундын ойн анги	3	3	-	3	3	-
Бүгд дүн	167	166	1	151	147	4

Эх сурвалж: Сумын ЗДТГ-ын Санхүүгийн албанаас мэдээллийг гаргуулж, тулган баталгаажуулсан

Боловсролын системд сумдын Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэгт мөрдөгдөх бүтэц, орон тооны жишиг байхгүй байна. Боловсролын салбарын бүтэц орон тооны асуудлыг аймгийн Боловсрол соёлын газарт албан тоотоор хүргүүлэхээр тогтов.

ХХОАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10-д “Хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хүнийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлнө” гэж заасан байхад 2015, 2016 онд

Сум дундын эмнэлэг хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингаас хувь хүний орлогын албан татварыг суутган тооцсон байна.

2015 оны 9 дүгээр сард Хүүхдийн цэцэрлэгийн багш Г.Эрдэнэцэцэгээс өмнөх сард илүү олгосон 3 өдрийн цалинг суутган тооцохдоо тооцооллыг буруу хийж 8.0 мянган төгрөг дутуу суутгасан байна.

Ахлах сургуулийн нягтлан бодогч нь 2015 оны 4 дүгээр сард ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохдоо цалингийн цэсэнд оруулан татвар, шимтгэл суутган тооцсон байна.

Дээрх зөрчлүүдийг арилган цалингийн суутгалыг хууль тогтоомжийн дагуу тооцон суутгаж байхыг зөвлөмж болгов.

Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30-ны 393 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш бусад албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгох журам”-ын 2.3-д “Төрийн өмчийн сургалтын байгууллагын багш бусад албан хаагчийн ажлыг үнэлж дүгнэх журамд заасан шалгуурын биелэлт 70-аас доош хувьтай үнэлэгдсэн тохиолдолд тухайн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохгүй”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 3 дугаар сарын 7-ны А/60 тоот тушаалын 5.5-д “Ажлын үнэлгээгээр 70-аас дээш оноо буюу сайн үнэлгээ авах нь ажилтан улирлын мөнгөн урамшил авах үндэслэл болно” гэж заасныг зөрчин Хүүхдийн цэцэрлэг улирлын ажил дүгнэлтээр 60-аас доош үнэлгээ авсан багш, ажилтнуудад улирлын урамшуулал олгосон, 3-р улирлын урамшууллыг олгохдоо ээлжийн амралттай байсан сарыг оруулан тооцсон байна.

Цаашид улирлын урамшууллыг олгохдоо бодит ажлын үр дүнг харгалзан журмын дагуу олгож байхыг зөвлөмж болгов.

Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг татварын байцаагчийн албан мэдэгдлийг үндэслэн буу, газар, байгалийн нөөц ашигласны төлбөр, авто тээврийн татвар зэрэг болон ойн хандивын мөнгийг цалингийн цэсээр шууд суутган авсан байна. Цаашид цалинг тооцон олгохдоо хуулиар заагдаагүй суутгал хийхгүй байхыг зөвлөв.

2015 онд Сум дундын эмнэлэг нь ажил хавсран ажилласны нэмэгдэлд бага эмч Б.Пүрэвжавд 104.6 мянга, Б.Анхбаярт 91.3 мянга, ахлах сувилагч С.Пүрэвсүрэнд 235.2 мянга, мэс заслын сувилагч Ж.Пүрэвдоржид 191.5 мянга нийт 622.6 мянган төгрөгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон байна. Цаашид цалингийн нэмэгдлийг олгохдоо эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу олгож байхыг зөвлөмж болголоо.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Хөдөлмөрийн чадвар түр хугацаагаар алдсан ажлын эхний 5 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно” гэж заасныг зөрчин 2015 онд Сум дундын эмнэлэг их эмч Ч.Энхтуяад хөдөлмөрийн чадвар түр алдсаны 10 хоногийн тэтгэмж нийт 219.0 мянган төгрөгийг ажил олгогчоос олгосон байна. Цаашид дээрх хуулийг мөрдөж ажиллахыг зөвлөлөө.

2015 онд сумын Засаг даргын захирамжаар Санхүүгийн алба байгуулагдаж ЗДТГ-ын даргын 2015 оны Б/14 дүгээр тушаалаар нягтлан бодогч С.Сарангэрэлийг Ахлах сургууль, Сум дундын эмнэлэгийг хариуцсан нягтлан бодогчоор томилсон байна.

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна” гэж заасныг зөрчин 2016 онд Сум дундын эмнэлэгийн

эрхлэгчийн тушаалаар нягтлан бодогчийг давхардуулан томилж 1.1 сая төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Дээрх зөрчлүүдийг таслан зогсоох, давтан гаргахгүй байхыг албан шаардлага болгов.

Сумын Засаг дарга Ц.Сүхбаатар 2015 онд Сум дундын эмнэлгийн дарга Н.Чимэдцэрэнгийн цалинг тогтоохдоо хүүхдийн эмчийг хавсран ажилласны нэмэгдэлийг 40 хувиар, мөн хүүхдийн эмчийн авах ёстой нэмэгдэл болох Засгийн газрын 150 дугаар тогтоолын нэмэгдлийг 10 хувиар давхардуулан тогтоосон байна.

Дээрх 150 дугаар тогтоолын нэмэгдлийг нягтлан бодогч С.Сарангэрэл тооцож олгохдоо 2015 оны 1, 2, 5 сар, 2016 оны 2, 3, 4, 5, 6, 9 сард хавсран ажилсны нэмэгдлээс нь 10 хувиар, 2015 оны 3, 4, 6, 7, 8, 9, 10, 11, 12 сар, 2016 оны 1, 7, 8, 10 сард эрхлэгч эмчийн үндсэн цалингаас 10 хувиар тооцож 2015 онд 490.2 мянга, 2016 онд 434.5 мянга, нийт 924.7 мянган төгрөг илүү олгосон байна.

Цаашид цалин, цалингийн нэмэгдлийг хууль журманд нийцүүлэн тогтоож байхыг зөвлөж байна.

1.3 Авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнасан байна.

Сумын төсөвт байгууллагуудын авлага, өр төлбөр дараах байдалтай байна.

Д/д	Байгууллагын нэр	Авлага		Өр, төлбөр	
		2015	2016	2015	2016
1	ИТХ	0	0	437.4	0
2	ЗДТГ	125.7	125.7	47892.2	
3	Ахлах сургууль	2761.8	41.4	12354.7	501.6
4	Хүүхдийн цэцэрлэг	80.5	80.5	16240.1	13.9
5	Сум дундын эмнэлэг	0	0	0	0
6	Соёлын төв	0	0	46.0	0
7	Сум дундын ойн анги	0	0	0	0
Нийт дүн		2968.0	247.6	76970.4	515.5

Эх сурвалж: Сумын ЗДТГ-ын Санхүүгийн албанаас мэдээллийг гаргуулж, тулган баталгаажуулсан

Судалгаанд тусгагдсан томоохон өглөг, авлага нь сумын ОНХС-ийн санхүүжилттэй холбоотой үүссэн байна.

УИХ-ын Төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ болон Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2016, 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн, Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийж дүн, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн.

Иймд дээрх асуудлыг аудитын шалгалтанд хамруулаагүй болно.

1.4 Төсөвт байгууллагууд бараа ажил үйлчилгээг хууль, тогтоомжийн дагуу бэлтгэн нийлүүлсэн байна.

Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 2015 онд 11 ажил хийснээс өмнөх оны 9, тайлант оны 3 ажил, 2016 онд 12 ажил хийснээс өмнөх оны 9, тайлант оны 3 ажил байна. ТБОНӨХБАҮХАТ хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор

баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-ын дагуу 2015 онд 1 ажилд нээлттэй тендер зарлаж, 1 ажилд шууд гэрээ байгуулсан, 2016 онд 1 ажилд нээлттэй тендер зарлаж, 1 ажилд шууд гэрээ байгуулан ажилласан байна.

Мөн сумын төсөвт байгууллагуудын түлш халаалт, тээвэр шатахуун, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Ахлах сургуулийн хоолны зардал, үдийн цай хөтөлбөрт харьцуулалтын арга ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Тендерт оролцсон аж ахуйн нэгж, иргэдийн бүлгээс 2015, 2016 онд 12 аж ахуйн нэгж, 6 иргэдийн бүлэг шалгарч гэрээ байгуулж бэлтгэн нийлүүлсэн байна.

Тендерт шалгарсан зарим бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний хавсралтанд нийлүүлэх бүтээгдэхүүний нэгж үнийг тусгаагүй, багц үнээр оруулсан байна. Цаашид гэрээний зүйл заалтыг тодорхой тусгаж байхыг зөвлөв.

Бүлэг: 2 Бараа материал болон үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

2.1. Боловсролын байгууллагууд шатахуун зарцуулалтын замын хуудас хөтлөөгүй, хяналт сул байна.

Аудитын явцад Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн хоолны материалын зарцуулалтыг хүүхдийн ирцийн тоо, жижүүрийн дэвтэр, холбогдох баримттай тулган шалгахад зөрчил гараагүй болно.

Ахлах сургууль 2015 онд 2000.0 мянга, 2016 онд 2000.0 мянга, Хүүхдийн цэцэрлэг 2015 онд 996.4 мянга, 2016 онд 891.0 мянга, Соёлын төв 2015 онд 266.0 мянга, 2016 онд 183.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулахдаа Монгол улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан “Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг мөрдөөгүй, шатахуун зарцуулалтын замын хуудас хөтлөөгүй байна.

Замын хуудсыг тухай бүр хөтөлж, шатахуун зарцуулалтын тооцоог бодож, хяналтыг сайжруулахыг зөвлөлөө.

2.1 Үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.4-д “Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өмч хамгаалах байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна” гэж заасны дагуу сумын төсөвт байгууллагуудын Төсвийн менежерийн шийдвэрээр өмч хамгаалах байнгын зөвлөлийг томилон ажиллуулсан байна.

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны А/38 дугаар тогтоолоор ИТХ, ЗДТГ, Ахлах сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Сум дундын эмнэлэг, Соёлын төвийн эзэмшилд байгаа ашиглалтын хугацаа дууссан, сэлбэж ашиглах боломжгүй болсон, эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон нэр бүхий хөрөнгийг данснаас хасаж акталж устгах үүрэг чиглэл өгсөн байна.

Дээрх тогтоолын дагуу сумын төсөвт байгууллагууд Орон нутгийн өмчийн газарт санал хүргүүлж шийдвэрлүүлсэн байна.

Ахлах сургууль, Сум дундын эмнэлэгт ашиглалтын хугацаа дуусаж шийдвэр нь гарсан ч актлаагүй хөрөнгө хадгалагдаж байна.



Аудитын явцад сумын төсөвт байгууллагуудад хөрөнгийн тооллого хийхэд Соёлын төв 2016 онд авсан 2 ш явуулын өсгөгч, Ахлах сургуулийн модон граж, тоглоомын талбайг тус тус данс бүртгэлд тусгаагүй мөн боловсролын байгууллагууд үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь буруу ангилж бүртгэсэн зөрчил байсанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-д “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана” гэж заасны дагуу үндсэн хөрөнгийг зөв ангилж данс бүртгэлд тусгахыг албан шаардлага болгов.

Шинэ зууны боловсрол хөтөлбөрийн хүрээнд Ахлах сургуулийн багш нарт 2015 онд шинээр зөөврийн компьютер олгосон байна. Гэтэл 2011 онд ирсэн 8 ш BAZ компьютерыг багш нараас буцааж аваагүй ашиглуулж байна. Тухайн хөрөнгийг буцаан авч байгууллагад зориулалтын дагуу ашиглахыг албан шаардлага болгов.

Ахлах сургуульд 2013 онд яамны хөрөнгө оруулалтаар нэг бүр нь 160.0 мянга, нийт 3200.0 мянган төгрөгийн өртөгтэй 20 ш морин хуур ирсэн байна. Энэ хөгжим нь сургалтын үйл ажиллагаанд ашиглах боломжгүй, шаардлага хангахгүй учир огт ашиглаагүй, мэргэжлийн хүнд үзүүлсэнд стандартын бус гэсэн тайлбарыг өгсөн байна.

Ахлах сургууль 2015 онд 390.0 мянга, 2016 онд 300.0 мянга, нийт 690.0 мянган төгрөгөөр автомашины дугуй худалдан авахдаа Монгол улсын дэд бүтцийн сайдын “Резинэн дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг батлах тухай” 2004 оны 19 дүгээр тушаалын 9 дүгээр хавсралтыг баримтлаагүй, гүйлтийн тооцоо бодоогүй, өмч хамгаалах зөвлөлөөс хүлээн авсан акт үйлдээгүй байна. Дээрх тушаалын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллахыг зөвлөв.

**Бүлэг: 3 Эмийн эргэлтийн сангаас зориулалт бус зардал
гаргасан байна.**

**3.1 Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийг
шинэчлэн байгуулаагүй байна.**

Аймгийн Засаг даргын 2013 оны А/674 дугаар захирамжаар баталсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ын 2.1-д аймагт эмийн эргэлтийн сан мэргэжлийн болон санхүүгийн удирдлагаар хангах удирдах зөвлөл, суманд эмийн эргэлтийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах сумын удирдах зөвлөл, хяналт тавих үүрэг бүхий хяналтын зөвлөл тус бүр ажиллана”, 4.4.1-д “Сумын эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл нь тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулагдана”, 4.4.2-д “Удирдах зөвлөл нь 5-аас доошгүй гишүүнтэй байх ба түүний бүрэлдэхүүнд сумын Засаг дарга, ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч, эмийн сангийн эрхлэгч, иргэд болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон байна. Удирдах зөвлөлийн дарга нь сумын Засаг дарга байна” гэж заажээ.

Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлийг журмын дагуу шинэчлэн байгуулж ажиллахыг зөвлөмж болгов.

**3.2 Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт хэвийн,
зориулалт бус зардал гаргасан байна.**

Аудитад хамрагдсан 2015, 2016 онд сумын Эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй, түүнд тавих хяналтын тогтолцоо байхгүй байна.

Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 3.3.1-д “Эмийн эргэлтийн сангийн хөрөнгө нь орон нутгийн өмч, гадаад байгууллагын тусламж, эмийн сангийн үйл ажиллагааны орлого болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заажээ.

Өндөрхангай сумын ЭЭС-анд 2015 онд борлуулалтын орлого 33.9 сая, эмийн үнийн хөнгөлөлт 6,9 сая, хүүгийн орлого 1,4 сая нийт 42.2 сая, 2016 онд борлуулалтын орлого 31,5 сая, эмийн үнийн хөнгөлөлт 7.2 сая, хүүгийн орлого 0.4 сая, нийт 39.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 3.3-д “Эмийн эргэлтийн сангийн эргэлтийн хөрөнгийг аймгийн Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 7 төрлийн үйл ажиллагаанд зарцуулах”-аар заажээ.

Сумын Засаг даргын 2015 оны 9 дүгээр сарын 02-ны А/78 дугаар захирамжаар сумын ЭЭС-аас дараах хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:

- ЭМТ-ийн автомашины дугуй шинэчлэх болон ком ээлж хийхэд 1025.0 мянга,
- Эмийн санч Т.Базармаагийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 742.9 мянга,
- Эмийн сангийн байр иж бүрэн тохижуулж, засвар хийхэд 4981.4 мянга

Мөн сумын ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор сумын ЭЭС-ийн эх үүсвэрээр “Хүүхдийн амны хөндийг эрүүлжүүлэх” хөтөлбөрт 10.0 сая төгрөг баталж 2016 онд 7.0 сая төгрөг зарцуулсан байна.

Цаашид эмийн эргэлтийн сангийн журмыг хэрэгжүүлэн ажиллах, зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулахыг зөвлөмж болгов.

3.3 Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хэвийн байна.

Сумын Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 4.3.3-д “Аймгийн Эрүүл мэндийн газар эмийн эргэлтийн сангуудаас шаардлагтай эм эмнэлгийн хэрэгслийн захиалгыг авч нэгтгэж нэгдсэн тендер зарлаж нийлүүлэгчийг сонгон шалгаруулж чанартай эмээр тасалдалгүй жигд хүртээмжтэй хангах ажлыг зохион байгуулна” гэж заасны дагуу аймгийн ЭМГ-аас тендер зарласан байна.

2015 онд 5 компаниас 30.1 сая, 2016 онд 6 компаниас 25.7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийсэн байна.

ТБОНӨХБАҮХАТ хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-ыг зөрчин тендер сонгон шалгаруулалт хийж гэрээ байгуулахгүйгээр 2015 онд 6 компаниас 33.6 сая, 2016 онд 5 компаниас 17.6 сая, нийт 51.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь бүтээгдэхүүний үнэ, тоо, чанарт тавих хяналтыг алдагдуулахад хүргэж байна. Засгийн газрын 2013 оны 68 дугаар журмаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөмж болгов.

Эмийн эргэлтийн сангийн эмийн үлдэгдэлд түүвэр тооллого хийж тулган баталгаажуулахад Сум дундын эмнэлгийн даргын 2015 оны 10 дугаар сарын 12-ны А/25 тоот тушаалаар ашиглалтын хугацаа дууссан 21 нэр төрлийн 671.7 мянга, 2016 оны 11 дүгээр сарын 29-ний А/31 тоот тушаалаар ашиглалтын хугацаа дууссан 41 нэр төрлийн 1112.3 мянган төгрөгийн эмийг тус тус акталсан байна.

3.4 Эмийн эргэлтийн сангийн авлагыг данс бүртгэлд тусгасан байна.

Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайланд 2015 онд 5.6 сая, 2016 онд 7.2 сая төгрөгийн авлага тусгасан байна.

Эмийн эргэлтийн сангийн эмийн үлдэгдэлд түүвэр тооллого хийхэд эмч нарт зээлдүүлсэн 949.0 мянган төгрөгийн эм боох материалыг бусдад зээлдүүлсэн байсныг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.4-д “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ” гэж заасныг үндэслэн төлүүлэхээр акт тогтоолоо.

Бүлэг: 4 Шилэн дансы тухай хуулийн хэрэгжүүлэн ажиллаж байна

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэвийн байна.

Шилэн дансны тухай хууль батлагдсанаар төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоо бүрдсэн.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2015 оны 2/04 тоот албан бичгээр “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлсэн байна. Увс аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн ЗДТГ-ын Дотоод хяналтын албанаас удаа дараа хяналт, шалгалт хийж зөвлөмж өгч ажилласан байна.

Аудит хийхэд сумын төсөвт байгууллагууд 2015, 2016 онд Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан мэдээллүүдийг Shilendans.gov.mn сайтад бүрэн оруулсан байна.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасны дагуу сумын төсөвт байгууллагууд мэдээллийн самбарт санхүүгийн мэдээ, мэдээллийг байршуулсан байна. Харин Ахлах сургууль, Соёлын төв 5-р сараас хойш сарын мэдээг байршуулаагүй байна.

Цаашид хуулинд заагдсан мэдээллийг хугацаанд байршуулж байхыг зөвлөв.



4.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Өндөрхангай сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Аудитын газраас 2014 онд нийцлийн аудит хийж 10.9 сая төгрөгийн 13 акт, 150.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 9 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн 2015, 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан байна.

Дүгнэлт

Энэхүү нийцлийн аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.Үүнд:

Өндөрхангай сумын ИТХ-ын дарга М.Цэрэндорж, Засаг дарга Ц.Сундуй, төсөвт байгууллагын менежерүүдэд:

1. Сум дундын эмнэлэг, Соёлын төвийн зарим ажилтныг ажлаас халж шүүхийн шийдвэрээр буцаж ороход нь шийдвэрийн дагуу ажлаагүй хугацааны цалинг олгосон байна.
2. Хүүхдийн цэцэрлэг багш, ажилтнуудад улирлын урамшуулал олгохдоо холбогдох заавар, журмыг мөрдөөгүй байна.
3. Боловсролын байгууллагууд шатахуун зарцуулалтын анхан шатны баримт замын хуудас хөтлөөгүй байна.
4. Ахлах сургууль, ЭМТ-д ашиглалтын хугацаа дууссан актлах шийдвэр гарсан хөрөнгө хадгалагдаж байна.
5. Эмийн эргэлтийн сангийн журмын хэрэгжилт хангалтгүй, зарцуулалтанд тавих хяналт сул байна.
6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хэвийн байна.
7. Өмнөх аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Өндөрхангай сумын ИТХ-ын дарга М.Цэрэндорж, Засаг дарга Ц.Сундуй, төсөвт байгууллагын менежерүүдэд:


1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.
2. Хүүхдийн цэцэрлэг багш, ажилтнуудад улирлын урамшуулал олгохдоо холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах.
3. Боловсролын байгууллагууд шатахуун зарцуулалтын замын хуудсыг бүрэн хөтөлж байх.
4. Ахлах сургууль, ЭМТ ашиглалтын хугацаа дуусаж актлах шийдвэр гарсан хөрөнгийг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэх.
5. Эмийн эргэлтийн сангийн журмыг хэрэгжүүлэн ажиллах, зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах.

Холбогдох байгууллагын санал


**УВС АЙМАГ
ӨНДӨРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА**
213411, Цэцэрлэг, Өндөрхангай сум
2017.10.20 № 196
танай _____-ны № _____-т

┌ УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ ┐

Тус суманд нийцлийн аудит хийхэд өгөгдсөн
үүрэг, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

ДАРГА  Ц.СУНДУЙ



Засаг дарга А.А.А. 85 0084

Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар

Өндөрхангай сумын Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 196 дугаар албан тоотоор нийцлийн аудитын тайлангийн төсөлд нэмж тусгах санал байхгүй гэсэн хариу ирүүлсэн болно.

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

Т.НАМЖИЛ
С.БАТСАЙХАН